



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/ЧО

Чингис хот

Эд хөрөнгийн тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 70.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын эд хөрөнгийн 2019 оны хагас жилийн тооллогыг 2019 оны 06 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд явуулсугай.

2. Эд хөрөнгийн тооллого явуулах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Д.Ганболд	-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Ж.Энхбат	-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Л.Наранбат	-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Ж.Цэнджав	-Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	Т.Баяртуяа	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав

3. Эд хөрөнгийн тооллогыг үнэн зөв чанартай, нэг бүрчлэн тоолж жагсаалтаар бүртгэн, дүнг 2019 оны 06 дугаар сарын 20-ны дотор танилцуулахыг комиссын дарга /Д.Ганболд/-д даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР